

**ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ГҮЙЦЭТГЭХ КОМИССЫН АЖЛЫН БИЕЛЭЛТ**

2023 оны 12 сарын 14

Налайх дүүрэг

Д/д	Төлөвлөгөөт ажил	Биелэлт
1	2022 оны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, албан хаагчдын баримт бичгийн стандартад хяналт, шалгалт хийх	2023 оны 03 сарын 13-17-ны өдрүүдэд Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, албан хаагчдын баримт бичгийн стандартад хяналт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж ажилласан. Албан хаагчид ХХНЖ-ын дагуу 2022 онд үүссэн баримт бичгүүдийг Захиргааны ажилтанд хуваарийн дагуу хүлээлгэн өгсөн, баримт бичгийн стандартыг хангаж ажилладаг. 2022 онд байнга хадгалах 30, 70 жил хадгалах 4, түр хадгалах 30, захирамжлалын цахим баримтын 2, цахим гэрэл зургийн 1, двд видео дүрс бичлэгийн 1, гэрэл зургийн цомог 32 зураг гээд нийт 100 баримт шинээр үүсч, архивын данс бүртгэлд бүртгэсэн байна.
2	2022 оны санхүү, нягтлан бодох бүртгэл, худалдан авалт, ханган нийлүүлэлтийн ажлын гүйцэтгэлд түүвэр шалгалт хийх	2023 оны 04 сарын 10-14-ны өдрүүдэд 2022 оны худалдан авах төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, няравын бүртгэл хөтлөлт, баримтын бүрдүүлэлтэнд түүвэр шалгалт хийлээ. Шалгалтаар гарсан зөрчилгүй, анхан шатны баримт бүрдэл хэвийн, 2022 онд 15,054.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 17,934.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 17,349.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлийг тайлагнасан байна.
3	2022 оны Байгууллагын тайлан, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хүний нөөцийн ажлын тайлан, Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний биелэлт, Сургалт хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, Ёсзүйн хорооны биелэлт, Мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааны биелэлт, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөөний биелэлт, Удирдах дээд байгууллагаас ирсэн тушаал шийдвэрийн биелэлт зэрэг тайлан, биелэлтүүдийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх	2023 оны 05 сарын 22-25-ны өдрүүдэд 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт болон хавсралт тайлангуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийлээ. Дотоод үйл ажиллагаатай холбоотой гардаг нийт 12 төлөвлөгөө, биелэлтэд хяналт тавьснаас тайлан биелэлтүүд цаг тухай бүртээ гардаг, хугацаа хоцроосон, зөрчилтэй асуудал байхгүй. <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан</li> <li>- Хүний нөөцийн ажлын тайлан</li> <li>- Нийгмийн баталгаага хангах төлөвлөгөө, биелэлт</li> <li>- Сургалт хөгжлийн төлөвлөгөө, биелэлт</li> <li>- Ёс зүйн хорооны биелэлт</li> <li>- Мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааны биелэлт</li> <li>- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөө, биелэлт</li> <li>- Удирдах дээд байгууллагаас ирсэн тушаал шийдвэрийн биелэлт</li> <li>- Гадаад үйл ажиллагааны тайлан</li> <li>- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт</li> <li>- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө</li> <li>- Архивын ажлын төлөвлөгөө, биелэлт</li> </ul>

4	2022 оны ажил дүгнэх ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг хангуулах, хяналт тавих	2023 оны 07 сарын 24-26-ны өдрүүдэд ажлын хэсгийн зөвлөмжийн хүрээнд 9 төрлийн чиг үүргийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын биелэлтэд хяналт тавьж ажилласан.
5	Хамтран ажиллах гэрээ байгуулсан байгууллагуудын 2022 оны гэрээний биелэлтэд хяналт шинжилгээ хийх	2023 оны 02 сарын 13-17-ны өдрүүдэд Парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан үйлдвэрүүдийн гэрээний биелэлтэд хяналт шинжилгээ хийсэн. 2022 онд нийт 37 ААН Паркт байрших хүсэлт ирүүлснээс 26 аж ахуйн нэгжтэй шинээр гэрээ байгуулж, 6 ААН-тэй хамтран ажиллах гэрээгээ сунгаж, нийт 32 ААН хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна. Гэрээнд тусгасан үндсэн 43 эрх, үүргийн дагуу үйлдвэрүүдийн гэрээг дүгнэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 25 ААН-тэй хамтран ажиллах гэрээг цуцлаж, 6 ААН-д хугацаат үүрэг даалгавар хүргүүлсэн байна.
6	2023 оны эхний хагас жилийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, албан хаагчдын баримт бичгийн стандартад хяналт, шалгалт хийх	2023 оны 09 сарын 11-14-ны өдрүүдэд 2023 оны эхний хагас жилийн архивын үйл ажиллагаа, стандартад хяналт шинжилгээ хийж, ХХНЖ батлах үйл ажиллагааг зохион байгуулсан. Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу бэлтгэл байдлыг хангаж ажиллахыг үүрэг болгосон.
7	Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журмуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, шаардлагатай бол дүрэм журамд өөрчлөлт оруулах санал боловсруулах	2023 оны 08 сарын 21-25-ны өдрүүдэд байгууллагын дотоодод мөрдөгддөг дүрэм журмуудын хэрэгжилт хяналт үнэлгээ хийсэн. Нийт 17 дүрэм, журам мөрдөгдөж ажилладагаас 2022 онд Газрын даргын А/01 тоот тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан байна. 2022 оны байдлаар дүрэм, журмууд зөрчигдсөн тохиолдол байхгүй. 2023 онд Албан хаагчдын ёс зүйн зөвлөлийн гишүүдийг шинэчлэж, ёс зүйн дүрмийг шинэчлэн батлахыг үүрэг болгосон.

ХЯНАСАН:  
ДАРГА  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.БАТЖАРГАЛ  
Н.ПҮРЭВСҮРЭН  
/2023 оны ... сарын ...-ны өдөр/

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
МАРКЕТИНГ, ОНХХ МЭРГЭЖИЛТЭН



Э.ЭНГҮҮН